

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дархан-Уул аймаг дахь Гаалийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** ДАА-2022/126/НА-СА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)  
Дархан-Уул аймаг  
2022 он

Тэргүүлэх аудиторын албан үүргийг  
түр орлон гүйцэтгэгч: **Ш.Мөнхбаяр**  
Утас: **7037-3089**  
Цахим хаяг: [munkhbayarsh@audit.gov.mn](mailto:munkhbayarsh@audit.gov.mn)  
Ахлах аудитор: **С.Батцэцэг**  
Утас: **7037-3089**  
Цахим хаяг: [battsetsegs@audit.gov.mn](mailto:battsetsegs@audit.gov.mn)  
Аудитор: **Б.Алтанзул**  
Утас: **9939-7390**  
Цахим хаяг: [Altanzulby@audit.gov.mn](mailto:Altanzulby@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу



**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

45059 Дархан-Уул аймаг,  
Дархан сум, 14-р баг  
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089  
E-mail: darkhanuul@audit.gov.mn

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ГААЛИЙН  
ГАЗРЫН ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ Д.ДАВААСҮРЭН ТАНАА

2022. 02. 25 № 725,  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ**



**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дархан-Уул аймаг дахь Гаалийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дархан-Уул аймаг дахь Гаалийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН  
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

/Ш.МӨНХБАЯР/

009020125



Нэг. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

		/ мянган төгрөгөөр/	
	Үзүүлэлт	2020.12.31	2021.12.31
<b>Санхүүгийн байдлын тайлан</b>			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	38,442.3	42,901.3
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,603,799.7	1,722,467.3
	<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>1,642,242.0</b>	<b>1,765,368.6</b>
	Нийт өр төлбөрийн дүн	-	472.7
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,642,242.0	1,764,895.9
	<b>Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>1,642,242.0</b>	<b>1,765,368.6</b>
<b>Санхүүгийн үр дүнгийн тайлан</b>			
	Үйл ажиллагааны орлогын дүн	803,643.1	859,705.8
	Үйл ажиллагааны зардлын дүн	666,389.7	737,027.3
	<b>Үйл ажиллагааны үр дүн</b>	<b>137,253.4</b>	<b>122,678.5</b>
	Үйл ажиллагааны бус үр дүн	-	(24.6)
	<b>Үйл ажиллагааны нийт үр дүн</b>	<b>137,253.4</b>	<b>122,653.9</b>
<b>Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан</b>			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,050,131.7	1,642,242.0
	Тайлант оны үр дүн	(407,889.7)	122,653.9
	<b>Эцсийн үлдэгдэл</b>	<b>1,642,242.0</b>	<b>1,764,895.9</b>
<b>Мөнгөн гүйлгээний тайлан</b>			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	<u>616,439,316.00</u>	<u>733,024,720.00</u>
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	<u>616,439,316.00</u>	<u>733,024,720.00</u>
	<b>Үйл ажиллагааны ЦМГ</b>	<b>0.0</b>	<b>0.0</b>
	<b>Хөрөнгө оруулалтын ЦМГ</b>	<b>0.0</b>	<b>0.0</b>
	<b>Санхүүгийн ажиллагааны ЦМГ</b>	<b>0.0</b>	<b>0.0</b>
	<b>Нийт цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>0.0</b>	<b>0.0</b>
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	0.0
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0	0.0
<b>Төсвийн гүйцэтгэлийн тайлан</b>			
		<b>Төлөвлөгөө</b>	<b>Гүйцэтгэл</b>
	<b>Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн</b>	734,207.4	722,345.7
	Урсгал зардал	734,207.4	722,345.7
	Хөрөнгийн зардал	0.0	0.0
	<b>Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр</b>	<b>734,207.4</b>	<b>722,345.7</b>
	Улсын төсвөөс санхүүжих	729,407.4	718,728.4
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	4,800.0	3,617.3

## **Хоёр. Байгууллага, түүний үйл ажиллагаа**

Дархан-Уул аймаг дахь Гаалийн газар нь мэргэшсэн, чадварлаг хүний нөөцийг бэхжүүлэх замаар үндэсний аюулгүй байдлыг хангаж, эдийн засгийн өрсөлдөх чадварыг дэмжин ажиллах эрхэм зорилгын хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлэн ажиллаж байна. Үүнд:

1. Олон улсын хууль ёсны худалдааг хөнгөвчлөх, түүний аюулгүй байдлыг хамгаалах,
2. Улсын хилээр хууль бусаар бараа, тээврийн хэрэгслийг нэвтрүүлэхтэй тэмцэх,
3. Улсын төсвийн орлогыг шударга, үр ашигтай, үр дүнтэй бүрдүүлэх,
4. Гаалийн байгууллагын дэд бүтэц, чадавхыг бэхжүүлэх

### **Гурав. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

ГЕГ-ын даргын 2020 оны 02 дугаар сарын 14-ны өдрийн Б/63 тоот тушаалаар Д.Даваасүрэнг ГЕГ-ын харъяа Дархан-Уул аймаг дахь Гаалийн газрын даргын албан тушаалд түр томилсноос хойш одоог хүртэл түр орлон гүйцэтгэгчээр ажиллуулж байгаа асуудлыг хуулийн хүрээнд шийдвэрлэхийг Гаалийн ерөнхий газрын даргад уламжилж байна.

### **Дөрөв. Аудитын гол асуудал**

Дархан -Уул аймаг дахь Гаалийн газрын 2021 оны санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудал байхгүй.

### **Тав. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим системд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 93,092.1 мянган төгрөгийн 2 гүйлгээг мэдээлээгүйд зөвлөмж өгөв.

### **Зургаа. Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц асуудал байхгүй болно.

**Долоо. Аудитын илрүүлэлт:** /Илрүүлсэн алдаа, зөрчлийн товч утга, түүнийг шийдвэрлэсэн байдал /хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал, залруулсан алдаа, төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмж//

Аудитаар нийт 118,946.9 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 19,836.8 мянган төгрөгийн 5 алдааг аудитын явцад залруулж, 1,233.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 97,876.7 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгсөн.

**7.1 Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл**

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо			Санал дүгнэлтийн хэлбэр				
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	<b>НИЙТ</b>	<b>1</b>	<b>1</b>			<b>1</b>			

**7.2 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:**

/сая төгрөгөөр/

№	Төсвийн захирагчийн ангилал	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
A	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
1	ТШЗ	8	118,946.9	5	19,836.8	1	1,233.0	0	-	2	97,877.1
2	Төсөл, хөтөлбөр										
3	ЗГТС										
4	ТТЗ										
5	ТЕЗ										
	<b>НИЙТ</b>	<b>8</b>	<b>118,946.5</b>	<b>5</b>	<b>19,836.8</b>	<b>1</b>	<b>1,233.0</b>	<b>0</b>	<b>-</b>	<b>2</b>	<b>97,877.1</b>